



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/464

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нэ:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн V.1.12-т тусгагдсан "Аварга нуурын зүүн бүрдийг сэргээх" ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Б.Мөнхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Нарийн бичиг	Г.Баярцэцэг	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны нөөц ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд	Т.Баатарсүх	Хэрлэн голын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	С.Баясгалан	Ус, цаг уур орчны шинжилгээний газрын Ус судлалын судалгааны инженер
	Г.Алимаа	Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын Улсын байцаагч
	М.Хишигбаяр	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Д.Урангоо	Дэлгэрхаан сумын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч
	Г.Цогтоо	Дэлгэрхаан сумын тавдугаар багийн малчин

2. Ажлын гүйцэтгэлд ажлын даалгавар дахь шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт тавьж, хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010748